

Баянзүрх дүүргийн Засаг даргын
2017 оны 12 дугаар сарын 12-ны
өдрийн А/Н/З/ дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДЭД ХӨТӨЛБӨР /2017-2020/

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэгдсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөр нь 1997 оноос тасралтгүй хэрэгжиж ирсэн байна.

Баянзүрх дүүргийн хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах дэд хөтөлбөр /2013-2016/-ийг хэрэгжүүлсэн хугацаанд:

- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүүргийн зөвлөлийг шинэчлэн байгуулсан.
- ✓ Аж ахуйн нэгж байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар, дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Royal HD телевиз гэх мэт газруудтай хамтран барилга угсралт, авто засварын газрууд, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад үзлэг шалгалтыг 4 удаа.
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр сургалтын эрх авсан төвүүдтэй хамтран аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт 8 удаа, мэргэшүүлэх сургалтыг 2 удаа, нийт ажилтаны сургалт 2 удаа.
- ✓ Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар болон Чингэлтэй, Баянгол дүүргүүдтэй хамтран галын аюулгүй ажиллагааны үзүүлэх сургалт гэх мэт нийт 30 гаруй ажлыг зохион байгуулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үндэсний зөвлөлд дэд хөтөлбөрийн биелэлтийг тайлагнан хөтөлбөрийг маш сайн хэрэгжүүлсэн үнэлгээ авсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дэд хөтөлбөр /2013-2016/-ийн хэрэгжих хугацаанд эрсдэл өндөртэй салбарууд болон хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтанд чиглэсэн үйл ажиллагааг түлхүү явуулсан бөгөөд цаашид төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн зүгээс эрүүл аюулгүй ажлын байрны орчинг бүрдүүлэх, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх ажилд шаардагдах хөрөнгийг жил бүр төсөвлөн санхүүжүүлэх арга хэмжээг авч байхмөн ажилтанбүрт аюулгүй ажиллагааны соёл, дадал заншлыг эзэмшүүлэхэд анхаарах, ажил олгогчийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх шаардлага чухлаар тавигдаж байна. Түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг сурталчилах, сургалт зохион байгуулах, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэл олгох шаардлага тавигдаж байгаа тул дүүргийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх үндэслэл болж байна.